



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/231/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8. Аудитын гол асуудал	18
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Б. МӨНХЗУЛ ТАНАА

2022.02.23 № СЭА-2022/231-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,838,462.33	66,603,894.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	35,000.00	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	35,000.00	0
31210	Төгрөг	35,000.00	0
31211	Төрийн сангийн харилцах	35,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	44,803,462.33	66,603,894.93
35100	Түүхий эд материал	9,600,146.00	32,862,701.00
35110	Тусгай зориулалттай материал	9,494,946.00	32,821,701.00
35130	Эм боох материал	105,200.00	41,000.00
35400	Хангамжийн материал	35,203,316.33	33,741,193.93
35410	Бичиг хэргийн материал	3,059,780.00	3,090,180.00
35420	Аж ахуйн материал	20,184,923.20	19,161,390.00
35440	Түлш, шатах тослох материал	1,031,000.00	0
35460	Хүнсний материал	2,866,832.20	1,971,182.00
35470	Бусад хангамжийн материал	8,060,780.93	9,518,441.93
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,198,162,461.08	1,177,312,775.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,198,162,461.08	1,177,312,775.61
39200	Биет хөрөнгө	969,940,725.88	949,308,989.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	939,612,572.98	939,612,572.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-48,175,497.64	-72,438,599.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,738,352.95	187,738,352.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	-160,488,352.87	-171,238,352.83
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	95,436,517.20	114,477,861.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67,497,743.95	-68,855,525.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,898,636.00	30,232,819.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,685,649.91	-17,059,647.51
39209	Зам, гүүрийн байгууламж	3,912,000.00	3,912,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-556,432.88	-818,816.12
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,746,324.00	3,746,324.00
39300	Биет бус хөрөнгө	228,221,735.20	228,003,786.52
39301	Программ хангамж	6,417,692.31	6,417,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,999,957.11	-6,217,905.79
39303	Бусад биет бус хөрөнгө	227,804,000.00	227,804,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,243,000,923.41	1,243,916,670.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	35,000.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,000.00	0
41300	Өглөг	35,000.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	35,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,242,965,923.41	1,243,916,670.54
51	Засгийн газрын хувь оролцоо	1,242,965,923.41	1,243,916,670.54
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	345,578,539.48	345,578,539.48
51200	Хуримтлагдсан үр дүн	327,807,336.76	328,792,680.71
51210	Өмнөх үеийн үр дүн	376,063,468.52	327,841,933.58
51220	Тайлант үеийн үр дүн	-48,256,131.76	950,747.13

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	569,580,047.17	569,545,450.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,243,000,923.41	1,243,916,670.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4317147908
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	682,049,016.00	715,816,636.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,397,116.00	54,529,836.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,397,116.00	54,529,836.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,137,400.00	1,825,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,137,400.00	1,825,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,290,000.00	27,425,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,969,716.00	25,279,136.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	669,651,900.00	661,286,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	669,651,900.00	660,786,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	669,651,900.00	660,786,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	730,305,147.76	714,865,888.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	730,305,147.76	714,865,888.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	721,552,111.68	709,240,583.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	482,890,237.34	495,182,753.20
210101	Үндсэн цалин	253,454,539.51	318,027,922.95
210102	Нэмэгдэл	208,365,414.03	156,341,730.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,079,700.00	20,813,100.00
210104	Урамшуулал	6,990,583.80	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,260,693.58	11,346,200.00
210201	Тэтгэврийн даатгал	717,494.91	1,487,808.34
210202	Тэтгэмжийн даатгал	67,528.95	131,889.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	84,411.17	164,861.99
210204	Ажилгүйдлийн даатгал	16,882.27	32,972.41
210205	Эрүүл мэндийн даатгал	9,374,376.28	9,528,667.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,259,499.50	60,629,257.81
210301	Гэрэл, цахилгаан	12,874,486.50	11,755,410.10
210302	Түлш, халаалт	41,546,443.00	41,544,442.00
210303	Цэвэр, бохир ус	6,838,570.00	7,329,405.71
2104	Хангамж, бараа материалын зардал	34,605,316.00	23,222,558.50
210401	Бичиг хэрэг	4,545,550.00	5,614,992.00
210402	Тээвэр, шатахуун	16,529,000.00	10,668,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,927,400.00	1,243,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	384,700.00	134,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,250,292.50	5,561,816.50
210408	Бараа материал акталсны зардал	5,968,373.50	0

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	54,681,543.60	39,876,373.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,205,600.00	761,400.00
210502	Хоол, хүнс	51,894,535.60	38,817,440.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,581,408.00	297,533.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,814,870.00	18,708,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	280,000.00	431,743,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	360,000.00	252,000.00
210604	Урсгал засвар	14,174,870.00	18,456,200.00
2107	Томилолт, зочны зардал	747,300.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	747,300.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,578,245.00	4,376,427.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,083,000.00	1,881,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,118.00	825,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	234,000.00	234,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00
210807	Газрын төлбөр	204,127.00	204,127.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,714,406.66	55,398,813.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,305,540.00	3,274,128.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,408,866.66	52,124,685.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,753,036.08	5,625,305.49
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	487,200.00	310,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	487,200.00	310,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,210,000.00	1,848,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,210,000.00	1,848,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,836.08	3,466,505.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,836.08	3,466,505.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-48,256,131.76	950,747.13
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-48,256,131.76	950,747.13

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	327,807,336.76	1,242,965,923.41
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	327,807,336.76	1,242,965,923.41
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	34,596.82	34,596.82
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	327,841,933.58	1,243,000,520.23
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-34,596.82	0	-34,596.82
6	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
8	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
9	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
10	Тайлант үеийн үр дүн	0	0	950,747.13	950,747.13
11	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	328,792,680.71	1,243,916,670.54

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	671,789,300.00	664,540,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,137,400.00	3,253,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,137,400.00	3,253,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,137,400.00	1,825,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,137,400.00	1,825,700.00
120009	Бусад орлого	0	1,428,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	669,651,900.00	661,286,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	669,651,900.00	660,786,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	669,651,900.00	660,786,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	668,554,400.00	660,725,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,554,400.00	660,725,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	659,801,363.92	655,100,194.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	482,890,237.34	496,610,753.20
210101	Үндсэн цалин	253,454,539.51	319,455,922.95
210102	Нэмэгдэл	208,365,414.03	156,341,730.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,079,700.00	20,813,100.00
210104	Урамшуулал	6,990,583.80	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,260,693.58	11,346,200.00
210201	Тэтгэврийн даатгал	717,494.91	1,487,808.34
210202	Тэтгэмжийн даатгал	67,528.95	131,889.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	84,411.17	164,861.99
210204	Ажилгүйдлийн даатгал	16,882.27	32,972.41
210205	Эрүүл мэндийн даатгал	9,374,376.28	9,528,667.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,259,499.50	60,629,257.81
210301	Гэрэл, цахилгаан	12,874,486.50	11,755,410.10
210302	Түлш, халаалт	41,546,443.00	41,544,442.00
210303	Цэвэр, бохир ус	6,838,570.00	7,329,405.71
2104	Хангамж, бараа материалын зардал	27,380,097.50	20,971,418.50
210401	Бичиг хэрэг	3,054,600.00	5,136,842.00
210402	Тээвэр, шатахуун	17,410,000.00	9,637,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,927,400.00	1,269,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	384,700.00	134,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,603,397.50	4,793,326.50
2105	Нормативт зардал	53,770,391.00	38,618,990.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,204,900.00	697,200.00
210502	Хоол, хүнс	52,565,491.00	37,921,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,661,300.00	19,099,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,590,100.00	391,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	360,000.00	252,000.00
210604	Урсгал засвар	13,711,200.00	18,456,200.00
2107	Томилот, зочны зардал	747,300.00	500,000.00

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	747,300.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,578,245.00	4,472,627.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,083,000.00	1,977,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,118.00	825,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	234,000.00	234,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00
210807	Газрын төлбөр	204,127.00	204,127.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,253,600.00	2,851,248.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,253,600.00	2,851,248.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,753,036.08	5,625,305.49
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	487,200.00	310,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	487,200.00	310,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,210,000.00	1,848,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,210,000.00	1,848,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,836.08	3,466,505.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,836.08	3,466,505.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,234,900.00	3,815,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,234,900.00	3,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,234,900.00	3,850,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,234,900.00	3,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,234,900.00	3,850,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,234,900.00	-3,850,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	-35,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,000.00	35,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,000.00	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	663,486,800.00	659,145,994.51	4,340,805.49	99.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	663,486,800.00	659,145,994.51	4,340,805.49	99.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662,579,600.00	658,415,194.51	4,164,405.49	99.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	498,726,800.00	496,610,753.20	2,116,046.80	99.58
210101	Үндсэн цалин	317,999,500.00	319,455,922.95	-1,456,422.95	100.46
210102	Нэмэгдэл	176,524,900.00	156,341,730.25	20,183,169.75	88.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,570,400.00	20,813,100.00	-18,242,700.00	809.72
210104	Урамшуулал	1,632,000.00	-	1,632,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,346,200.00	11,346,200.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	-	1,487,808.34	-1,487,808.34	-
210202	Тэтгэмжийн даатгал	-	131,889.68	-131,889.68	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	164,861.99	-164,861.99	-
210204	Ажилгүйдлийн даатгал	-	32,972.41	-32,972.41	-
210205	Эрүүл мэндийн даатгал	11,346,200.00	9,528,667.58	1,817,532.42	83.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,629,300.00	60,629,257.81	42.19	100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,866,800.00	11,755,410.10	-1,888,610.10	119.14
210302	Түлш, халаалт	44,990,800.00	41,544,442.00	3,446,358.00	92.34
210303	Цэвэр, бохир ус	5,771,700.00	7,329,405.71	-1,557,705.71	126.99
2104	Хангамж, бараа материалын зардал	20,972,900.00	20,971,418.50	1,481.50	99.99
210401	Бичиг хэрэг	1,820,000.00	5,136,842.00	-3,316,842.00	282.24
210402	Тээвэр, шатахуун	14,989,100.00	9,637,500.00	5,351,600.00	64.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,663,700.00	1,269,750.00	393,950.00	76.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	333,400.00	134,000.00	199,400.00	40.19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,166,700.00	4,793,326.50	-2,626,626.50	221.23
2105	Нормативт зардал	38,250,000.00	38,118,990.00	131,010.00	99.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	823,400.00	697,200.00	126,200.00	84.67
210502	Хоол, хүнс	37,426,600.00	37,421,790.00	4,810.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,119,000.00	22,949,700.00	1,169,300.00	95.15
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,741,700.00	4,241,500.00	500,200.00	89.45
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	324,000.00	252,000.00	72,000.00	77.78
210604	Урсгал засвар	19,053,300.00	18,456,200.00	597,100.00	96.87
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,107,100.00	4,437,627.00	669,473.00	86.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,611,700.00	1,942,300.00	669,400.00	74.37

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,200.00	825,200.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	234,000.00	234,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	204,200.00	204,127.00	73.00	99.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,928,300.00	2,851,248.00	77,052.00	97.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,928,300.00	2,851,248.00	77,052.00	97.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	907,200.00	730,800.00	176,400.00	80.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	487,200.00	310,800.00	176,400.00	63.79
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	487,200.00	310,800.00	176,400.00	63.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	420,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	663,486,800.00	659,368,994.51	4,117,805.49	99.38
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	660,786,800.00	657,543,294.51	3,243,505.49	99.51
310001	Улсын төсвөөс санхүүжих	660,786,800.00	657,543,294.51	3,243,505.49	99.51
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,700,000.00	1,825,700.00	874,300.00	67.62
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,700,000.00	1,825,700.00	874,300.00	67.62
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	69	69	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	34	34	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34	34	0.00	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	34	34	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

4/17/21
 2021.07.17
 /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4317 500,000.00
2105	Нормативт зардал	-	500,000.00
210502	Хоол хүнс	-	500,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй неец хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар *Цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гэх/-ын* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх тухай болон бараа материалын зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь “*Байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх*” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ашиглалтыг эрчимжүүлэх,
- Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх,
- Шударга ёс, ил тод байдлыг хангаж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүндрэлгүй зохион байгуулах,
- Нийт бие бүрэлдэхүүний цэрэгжилт, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 682,049.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,820.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 5,115.3 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 915.8 мянган төгрөгөөр буюу 0.07 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	35.00	-	(35.00)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	44,803.40	66,603.90	21,800.50
Үндсэн хөрөнгө	1,198,162.50	1,177,312.80	(20,849.70)
Нийт хөрөнгө	1,243,000.90	1,243,916.70	915.80
Өр төлбөр	35.00	-	(35.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,242,965.90	1,243,916.70	950.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,243,000.90	1,243,916.70	915.80

Бараа материалын дансны үлдэгдэл 66,603.9 мянган төгрөг болж, 21,800.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 79,621.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ШШГЕГ, Хорих ял эдлүүлэх албанаас нийт 25,279.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 83,100.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,513,941.6 мянган төгрөг болж 18,375.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3,850.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон ШШГЕГ-аас 3,900.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 23,525.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын даргын 2021 оны 576 тушаалаар 12,899.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,243,916.7 мянган төгрөг болж 950.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 33,767.6 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгө 42,444.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 8,865.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 15,439.3 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардал

12,292.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, хангамж, бараа материалын зардал 11,382.7 мянган төгрөгөөр, нормативт зардал 14,805.2 мянган төгрөгөөр тус тус буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 802,655.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 139,168.7 мянган төгрөгөөр бууруулж, 663,486.8 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшил 10,152.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 49,851.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 22,997.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 21,881.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 8,071.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 10,892.8 мянган төгрөгөөр буурч батлагдсан нь голлон нөлөөлсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 663,486.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс **663,486.8** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **659,146.0** мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил 2,116.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 1,169.3 мянган төгрөгөөр хэмнэгдэж, оны эцэст төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.


Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжаар хуваарилсан 500.0 мянган төгрөгийг хүлээн авч, хоол, хүнсний зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг “0” болсон 215,967.3 мянган төгрөгийн 66 нэр төрлийн хөрөнгийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2. Тайлант онд хоол хүнсний материал худалдан авах ажиллагааг цахимаар 1 удаа зохион байгуулж, нэг ч компани материал ирүүлээгүй гэсэн шалтгаанаар хоол хүнсний материалын худалдан авалт хийсэн тухай бүр харилцагч байгууллага, иргэнтэй гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Шууд гэрээ байгуулсан байгууллага, иргэн нь тендерийн баримт бичигт заасан шаардлагуудыг хангасан талаар нотлох баримтыг бүрдүүлээгүй байгаа тул цаашид тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу харилцагч байгууллагын чадавхыг үнэлж, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллах шаардлагатай байна.

3. ШШГЕГ-ын даргын 2021 оны А/11 дүгээр “Ахмадын сан байгуулах тухай” тушаалын дагуу тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 1,428.0 мянган төгрөгийг ахмадын сангийн харилцах 100130012502 тоот дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж, батлуулсны үндсэн дээр шилжүүлж байх шаардлагатай.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.



3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	1	-	1	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 57,345.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 54,367.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасны дагуу заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Бараа материалын зарцуулалттай холбоотой

2.1 Илрүүлэлт: Жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн албан хаагчид олгох хүнсний хангалтын махны нормыг зөрүүтэй /226 гр олгохоос 500 гр олгосон/ тооцож, 2,978.6 мянган төгрөгийн илүү зарцуулалт гаргасан байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Засгийн газрын 2018 оны 261 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний хангалтын хэмжээ”-нд “Шөнийн ээлжид болон ажлын бус цагаар үүрэг гүйцэтгэх үед-мах 226 гр” гэж заасныг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцож, зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	2	57,345.9	-	-	-	-	-	-	2	57,345.9